

**“ЭРҮҮЛ МЭНДИЙН
БАЙГУУЛЛАГЫГ МАГАДЛАН
ИТГЭМЖЛЭХ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТҮҮД”-ЭЭР ӨӨРИЙН
ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧЛАЛ**

**Эмнэлгийн тусламжийн
газар**

Шалгуур үзүүлэлтүүдээр өөрийн үнэлгээ хийх

- Зорилго нь тухайн эрүүл мэндийн байгууллага өөрийн үйл ажиллагаа болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдалдаа дүн шинжилгээ хийж, магадлан итгэмжлэлд бэлтгэх
- Магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг судалж, шалгуур үзүүлэлт бүрээр үйл ажиллагаандаа дүн шинжилгээ хийх
- Магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллага нь итгэмжлэлийн хугацаанд чанарын хөгжлийн хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, чанар сайжруулах ажлыг тасралтгүй явуулсан байх
- Анх удаа магадлан итгэмжлэлд орох байгууллагууд нь магадлан итгэмжлэлд бэлтгэх, тусламж үйлчилгээний чанар сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх.

Хэн, хэзээ, яаж хийх вэ

Багаар ажиллах
Мэдээлэл авах
Сургалтад хамрагдах
Хэмжилт хийх
Сайжруулах
Төлөвлөх
Хэрэгжүүлэх
Дахин хэмжих

- 1 жилээс доошгүй хугацаанд



Шалгуур үзүүлэлтүүдээр өөрийн үнэлгээ хийх

- Эрүүл мэндийн салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль эрх зүйн баримт бичгүүдийг судлах, тухайн шатлалын эрүүл мэндийн байгууллагад хамаарах үйл ажиллагаа, заалтыг хэрэгжүүлэх, мөрдөх;
- Тусамж, үйлчилгээний чанараа сайжруулах үйл ажиллагааг тасралтгүй явуулж, ахиц дэвшил гаргаж, тодорхой үр дүнд хүрэх зорилт тавин ажилласан байх
- Тусламж, үйлчилгээний технологи, аргачлалыг мөрдөж, үйлчлүүлэгчдэд аюулгүй, чанартай тусламж, үйлчилгээг үзүүлж, үр дүнд хүрсэн байх

Шалгуур үзүүлэлтүүдээр өөрийн үнэлгээ хийх

- Өөрийн үнэлгээ хийх нь тухайн байгууллага, хамт олон үйл ажиллагаандаа байгаа давуу, сул тал болон тусламж үйлчилгээнийхээ чанарыг сайжруулахад шаардлагатай асуудлаа тодорхойлж, шийдвэрлэх арга замуудыг төлөвлөж, хэрэгжүүлэхэд;
- Эрүүл мэндийн байгууллагын ажилтан бүрийг тусламж, үйлчилгээний чанар сайжруулах болон магадлан итгэмжлэлд бэлтгэх үйл ажиллагаанд оролцуулж, хэн ямар хугацаанд, ямар ажлыг хариуцан гүйцэтгэхийг төлөвлөн хэрэгжүүлэхэд;
- Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар тасралтгүй сайжирч, өмнөх магадлан итгэмжлэгдсэн үетэй харьцуулахад ямар ахиц дэвшил гарсныг тодорхойлох, дүгнэлт өгөхөд;

“Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүд” /ЭМС-ын 2014 оны 07 дугаар тушаал/

- Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг;
- Нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг;
- Сум дундын эмнэлгийг;
- Сум, тосгоны эрүүл мэндийн төвийг;
- Өрхийн эрүүл мэндийн төвийг;
- Сувиллыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүд:
 - Сувиллын цогцолбор, сувиллын газар
 - Улирлын үйл ажиллагаатай сувилал

“Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүд”

3 бүлэгтэй:

бүлэг 1. Удирдлага, бүтэц, зохион байгуулалт

бүлэг 2. Тусламж, үйлчилгээний технологийн
мөрдөлт

бүлэг 3. Эрүүл ахуйн нөхцөл, халдварын
сэргийлэлт, хяналт, техникийн үйлчилгээ

3.1 Эрүүл ахуйн нөхцөл, халдварын
сэргийлэлт, хяналт

3.2 Техникийн үйлчилгээ

Шалгуур үзүүлэлтүүдээр өөрийн үнэлгээ хийх

CD/, хичээлүүдийг ашиглах;

Үнэлгээ хийх:

- Шалгуур үзүүлэлтийн чиглэл
- Шалгуур үзүүлэлтийн тодорхойлолт
- Шалгуур үзүүлэлтийн тайлбар
- Мэдээллийн эх үүсвэр, үнэлэх аргачлал
- Үнэлгээ

Өөрийн үнэлгээ хийхэд анхаарах асуудлууд:

1. Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлтийг сонгох:
Байгууллагын нэр, тусламж, үйлчилгээний төрлийг үндэслэн өөрийн байгууллагад хамаарах магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдээр үнэлгээ хийнэ.
 - Улсын хэмжээнд тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн эмнэлэг нь “Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдээр;
 - Аймаг, нийслэлийн хэмжээнд тусламж, үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хувийн хэвшлийн эмнэлэг нь “Нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, түүнтэй адилтгах хувийн хэвшлийн эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдээр;

ҮРГЭЛЖЛЭЛ

-Улсын хэмжээнд болон аймаг, орон нутагт жилийн турш үйл ажиллагаа явуулдаг рашаан сувилал, сувилал нь “Сувиллын цогцолбор, сувиллын газрыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтээр;

- Жилийн турш үйл ажиллагаа явуулдаггүй аймаг, орон нутгийн рашаан сувилал, сувилал нь “Улирлын үйл ажиллагаатай сувиллыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдээр

-Сум, тосгон, өрхийн эрүүл мэндийн төвийг

-Сум дундын эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтүүдээр тус тус үнэлгээ хийнэ.

2. Байгууллага нь мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд бичигдсэн тусламж, үйлчилгээний чиглэл, төрөл бүрээр шалгуур үзүүлэлтэд заагдсан үзүүлэлт бүрээр үнэлгээ хийнэ.
3. Өөрийн үнэлгээний тайланд магадлан итгэмжлэлийн хугацаанд хийсэн үйл ажиллагааг бүхэлд нь нэгтгэн дүгнэж бичнэ.
4. Үнэлгээг багаар хийнэ. Өөрийн үнэлгээ нь тухайн байгууллагын үйл ажиллагаа, тусламж үйлчилгээний чанарыг бүхэлд нь харуулдаг тул үнэлгээг зөвхөн удирдах ажилтан, чанарын алба/багийн гишүүд бус эмнэлгийн ажилтнуудыг оролцуулан хамтран хийж, тайланг бичнэ.

5. Өөрийн үнэлгээ үнэн зөв, бодитой байх.

Шалгуурын үзүүлэлт бүрээр тайлбарыг бичих ба тухайн үйл ажиллагаатай холбоотой үнэн зөв, бодит мэдээ, мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийж, нэгтгэн дүгнэж бичнэ.

6. Өөрийн үнэлгээний тайланг товч, тодорхой бичих. Шалгуурын үзүүлэлтийн тайлбарт тухайн асуудлын хүрээнд хийсэн ажлын зорилго, зохион байгуулсан үйл ажиллагаа, гарсан зардал, ажлын үр дүнг тоо, баримтад тулгуурлан бичнэ. Тухайн үйл ажиллагааг бүрэн гүйцэтгэж, үр дүн гарсан бол шалгуурыг хангасан гэж үнэлнэ.

7. Өөрийн үнэлгээнд ЭМЯ-ны вэб хуудас дах “Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэл” буланд байршуулсан үнэлгээний оноо тавьсан шалгуур үзүүлэлтүүдийг ашиглана. /татаж авахаар байршуулсан/

8.Өөрийн үнэлгээний тайланд үнэлгээний багийн гишүүд гарын үсэг зурах ба мөн тухайн байгууллагын дарга, захирал гарын үсэг зурж баталгаажуулна.

9. Өөрийн үнэлгээний тайланг А4 хэмжээтэй цаасан дээр Arial үсгийн фондоор, үсгийн өндөр 11, 12-оор бичих ба хэвтээ хэлбэртэй байна.

10. Байгууллага нь магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан гэж үзвэл магадлан итгэмжлүүлэх хүсэлтээ гаргана.

ЭМБ-ын бүтэц, үйл ажиллагааны стандартаар үнэлгээ хийх, арга хэмжээ авах, хэгжүүлсэн байх .

1. Сум, тосгоны эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5081:2013 стандарт

2. Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5292:2011 стандарт

3. Сувиллын бүтэц, үйл ажиллагаа MNS 5232:2013 стандарт

4. Амаржих газар MNS 6188:2010 стандарт

5. Уламжлалт анагаах жхааны ор бүхий эмнэлэг, амбулаторийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5700:2006

Стандартын үнэлгээ хийсэн байх

6. Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5095:2013 стандарт

-Хувийн хэвшлийн эмнэлгүүд

7. ЭМБ-ын бүтэц, үйл ажиллагаа /Төв эмнэлэг MNS 6330-1, Тусгай мэргэжлийн төв 6330-2, 3, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв 6330-4:2012/ стандарт

-Хүний нөөцийн хангалт / тоо, хувь/

-Тоног төхөөрөмжийн хангалт /тоо, хувь, жагсаалт гаргах/

-Тасаг, нэгжийн талбайн хэмжээ /шаардлагатай өрөө, нэгжид ногдох талбайн хэмжээг стандарттай харьцуулах/

Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Шалгуур үзүүлэлтийг бүрийг 100, 0 эсвэл 100, 50, 0 оноогоор үнэлнэ.

- Шалгуур үзүүлэлт бүрийг бүрэн хангасан бол тус бүрд 100 оноо өгөх ба онооны нийлбэрийн дундажаар тухайн үнэлэх чиглэлийн оноо гарна. Харин хувиар тооцож үнэлэх үзүүлэлтэд оноог тэр хэвээр авна.

- 100, 0 оноогоор үнэлгээ өгөх: шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан бол 100 оноо, үзүүлэлтийг дутуу хангасан ба хангаагүй бол 0 оноогоор үнэлнэ.

Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

- 100, 50, 0 оноогоор үнэлгээ өгөх: шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан бол 100 оноо, үзүүлэлтийг хангах талаар арга хэмжээ авсан боловч үр дүн нь гараагүй бол 50 оноо, үзүүлэлтийн үр дүн гараагүй ба үзүүлэлтийг хангаагүй бол 0 оноо өгнө.
- Тухайн үзүүлэлтийг үнэлэхээр бичигдсэн оноог өөрчилж болохгүй.

Шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дүн

Дүнг гаргахдаа бүлэг тус бүрийн онооны дундажийг, дараа нь 3 бүлэг тус бүрийн онооны нийлбэрийг бүлгийн тоо (3)-нд хувааж эцсийн дүн (**дундаж хувь**) -г гаргана.

Жишээ нь: Сум дундын эмнэлгийг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт
бүлэг 1 – 6 чиглэл/29 шалгуур үзүүлэлттэй
бүлэг 2 - 33 чиглэл/110 шалгуур үзүүлэлттэй
бүлэг 3 - 12 чиглэл/65 шалгуур үзүүлэлттэй
Үнэлэх чиглэл бүрийн онооны нийлбэрийн дундажаар тухайн чиглэлийн оноог гаргана.


Шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Зарим шалгуур үзүүлэлт тухайн байгууллага (хувийн хэвшлийн эмнэлэг)-д хамаарахгүй бол тайлбарт хамаарахгүй гэж бичнэ. Харин шалгуурт байгаа үзүүлэлтээс аль нэг нь хамаарахгүй бол тухайн үзүүлэлтийг мөн хамаарахгүй гэж бичих ба оноо өгөхдөө хасаж үнэлнэ. Жишээ нь: 3 шалгуур үзүүлэлтийн 2 үзүүлэлт хамаарч байгаа бол тус бүрт 100 оноо өгсөн бол онооны дундажийг гаргахдаа хамаарахгүй үзүүлэлтийг хасаж ($200 : 2$ үзүүлэлт = 100 оноо) дүгнэнэ.

Харин эрүүл мэндийн байгууллага нь шалгуур үзүүлэлтэд тусгасан үйл ажиллагааг хэрэгжүүлээгүйн улмаас шалгуурыг хамаарахгүй гэж хасаж дүгнэж болохгүй.

Шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дүн

Бүлэг	Шалгуур үзүүлэлтийн бүлэг	Байгууллагын өөрийн үнэлгээ			Шинжээчийн үнэлгээ		
		Үнэлгээний нийт оноо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Дундаж хувь	Үнэлгээний нийт оноо	Шалгуур үзүүлэлтийн тоо	Дундаж хувь
1	Удирдлага, бүтэц, зохион байгуулалт						
2	Тусламж үйлчилгээний технологийн мөрдөлт						
3	Эрүүл ахуйн нөхцөл, халдварын сэргийлэлт, хяналт, техникийн үйлчилгээ						
	Нийт дүн /хувь/						



Анхаарал хандуулсанд баярлалаа